



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 05/
32-03

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр баталсан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болон түүний харьяа газар, хэлтсийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023-2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар газрын дуудлага худалдааны орлогыг төлөвлөхдөө дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлалын дагуу тооцоогүйгээс 2023 онд 412,796.300 төгрөг, 2024 онд 303,032.900 төгрөг нийт 715,829.200 төгрөгөөр дутуу төлөвлөж төсвийн орлогыг бодитоор үнэн зөв төлөвлөөгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2 дахь "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Газрын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу тухайн шатны Засаг дарга тогтооно.", Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал"-ын 3.1-д "Хот, тосгон, бусад суурины газарт газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлохдоо энэхүү аргачлалын 1.3.3, 1.3.4, 1.3.5, 1.3.6-д заасныг үндэслэнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

4325005015

1. Газрын дуудлага худалдааны орлогыг төлөвлөхдөө дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлалын дагуу тооцож төсвийн орлогыг бодитоор үнэн зөв төлөвлөх.
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Б.Саруултөгс, Газрын удирдлагын хэлтсийн дарга А.Алтанцэцэг нарт даалгав.
3. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧИ



Ц.УРТНАСАН

ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА



Б.САРУУЛТӨГС

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

А.АЛТАНЦЭЦЭГ